

ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2026.05.25

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Зах зээл үүсгэх анхны захиалгууд байршиж эхэллээ.
- Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдийн хамгийн өндөр өсөлтийн нэгийг үзүүллээ.
- Нийлүүлэлтийн цочрол инфляцыг хоёр оронтой тоонд хүргэв.
- МХБ болон BGM asset management хамтран 800 гаруй шилдэг компанийг багтаасан FTI индексийг танилцууллаа.

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.58%	-1.21%	-6.46%
MSE A	-0.12%	-1.64%	-6.89%
MSE B	0.65%	0.29%	-0.26%

2026/05/18 – 2026/05/22

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
KHAN	623,412,210.00
SBM	499,972,512.84
MSE	125,890,799.60
QPAY	117,064,340.59
GLMT	100,372,038.00

2026/05/18 – 2026/05/22

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
ADU	399.50	28.87%
ATR	34,500.00	15.00%
DAR	4,830.00	15.00%
MIB	69.00	15.00%
TVT	3,967.00	14.99%

2026/05/18 – 2026/05/22

2026 он 05-р сарын 25

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,282

ТОП-20 индекс

50,961

MSE A

19,389

MSE B

14,324



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

7.9%

2026 - I улирал

Инфляц

10.1%

2026-04 сар

ГВУН(сая\$)

7,327.07

2026-04 сар

Бодлогын
хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

5.6%

USD/MNT

3,576.42

2026-05-24



Эдийн засгийн мэдээлэл

ЭДИЙН ЗАСАГ СҮҮЛИЙН ЖИЛҮҮДИЙН ХАМГИЙН ӨНДӨР ӨСӨЛТИЙН НЭГИЙГ ҮЗҮҮЛЛЭЭ


2026 оны эхний улиралд Монгол Улсын эдийн засаг өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар өсөж, сүүлийн жилүүдийн хамгийн өндөр өсөлтийн нэгийг үзүүлээ. Энэхүү өсөлтийг голлон уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн огцом тэлэлт дэмжсэн бөгөөд экспортын эрэлт, ялангуяа нүүрс болон зэсийн баяжмалын олборлолт, тээвэрлэлтийн өсөлт хүчтэй нөлөө үзүүлсэн байна.

Салбарын бүтцээр нь авч үзвэл уул уурхайн салбар 33.6 хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийн 5 нэгж хувийг дангаараа бүрдүүлжээ. Нүүрсний олборлолт 38.3 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 4 хувиар, зэсийн баяжмалын үйлдвэрлэл 30 хувиар өссөн нь уул уурхайн өсөлтийн суурь хүчин зүйл болсон байна. Түүнчлэн тээврийн салбар 23.8 хувиар өссөн нь нүүрсний экспортын тээвэр эрчимжсэнтэй шууд холбоотой байв.

Харин боловсруулах үйлдвэрлэл болон худалдааны салбар эдийн засгийн өсөлтийг сааруулсан хэвээр байна. Боловсруулах үйлдвэрлэл 6.6 хувиар агшсан нь мах боловсруулах, ундааны үйлдвэрлэл болон зарим үйлдвэрлэлийн биет хэмжээ буурсантай холбоотой байв. Мөн худалдааны салбар 0.8 хувиар буурсан нь хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа сул байгааг илэрхийлж байна. Энэ нь эдийн засгийн өсөлт өргөн хүрээнд тархаагүй, уул уурхайн салбарт төвлөрсөн хэвээр байгааг харуулж буй чухал дохио юм.

Өөрөөр хэлбэл, одоогийн эдийн засгийн өсөлт нь дотоодын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын өргөжилтөөс илүүтэйгээр уул уурхайн экспортын циклээс хамааралтай хэвээр байгаа нь ажиглагдаж байна.

График: Эдийн засгийн өсөлт /салбараар/






Эдийн засгийн мэдээлэл

НИЙЛҮҮЛЭЛТИЙН ЦОЧРОЛ ИНФЛЯЦЫГ ХОЁР ОРОНТОЙ ТООНД ХҮРГЭВ

Монгол Улсын инфляц 2026 оны 4-р сард 10.1 хувьд хүрч, өмнөх оны мөн үеийн 8.6 хувиас 1.5 нэгж хувиар, 2025 оны жилийн дүнгийн 7.5 хувиас 2.6 нэгж хувиар тус тус өслөө. Энэ нь инфляц хоёр оронтой тоонд орж Монголбанкны зорилтот дээд хязгаараас мэдэгдэхүйц хэтэрсэн байна.

Нийт инфляцын 7.2 нэгж хувь буюу 71 орчим хувийг дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт бүрдүүлж байна. Үлдсэн 2.9 нэгж хувь буюу 29 хувийг импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт тайлбарлаж байна. Өөрөөр хэлбэл, инфляцын гол өөрчлөлт нь гадаадаас биш, харин дотоодын зах зээлд байна.

График: Инфляцын бүрэлдэхүүн



■ Дотоодын бараа, үйлч. ■ Импортын бараа

Хонины мах +41.5%

Хаврын мал хорогдол, нийлүүлэлтийн дутагдал

Дизель түлш +34.0%

Олон улсын газрын тосны үнэ (+50%) нөлөөлсөн

Гурил, гурилан бүтээгдэхүүн +8.8%

Нийлүүлэлтийн асуудал

Сүү, сүүн бүтээгдэхүүн +6.8%

Дотоодын үйлдвэрлэлийн зардал нэмэгдсэн

Суурь инфляц 5.9%

Хүнс, шатахуун хасч тооцсон эрэлтийн инфляц

Хонины мах 41.5 хувиар өссөн нь нийт инфляцад хамгийн том нөлөө үзүүлсэн хүчин зүйл болжээ. Энэ нь хаврын улирлын мал хорогдлын шууд үр дагавар юм. 2026 оны эхний улиралд том малын зүй бус хорогдол 178 мянган толгойд хүрч, өмнөх оны мөн үеэс 94 мянгаар өссөн нь малын тоо толгой буурч, нийлүүлэлтийн дутагдал үүсгэсэн.

Дизель түлшний үнэ 34.0 хувиар нэмэгдсэн нь импортын инфляцын гол өөрчлөлт болов. Brent газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ 2026 оны 4-р сард 96 ам.долларт хүрч өмнөх оноос 50 хувиар өссөн нь шатахуун, тээврийн зардлаар бүхий л эдийн засагт нэвтэрч байна.

Гурил болон гурилан бүтээгдэхүүний үнэ 8.8 хувиар өссөн нь үйлдвэрлэлийн зардал нэмэгдсэнтэй холбоотой. Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндгийн үнэ 6.8 хувиар нэмэгдсэн нь малын аж ахуйн хямрал болон тэжээлийн өртөг нэмэгдсэнтэй холбоотой байна.



Зах зээлийн мэдээлэл

ЗАХ ЗЭЭЛ ҮҮСГЭХ АНХНЫ ЗАХИАЛГУУД БАЙРШИЖ ЭХЭЛЛЭЭ

Голомт Капитал ҮЦК ХХК нь Монгол Улсад анхлан зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна. 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Монос Хүнс ХК-ийн (MFC.MSE) хувьцаан дээр зах зээл үүсгэх анхны авах, зарах захиалгууд албан ёсоор байршиж эхэллээ.

Уг үйл ажиллагааны хүрээнд Голомт Капитал ҮЦК ХХК нь дараагийн 6 сарын хугацаанд арилжааны цагийн 50-аас доошгүй хувьд хоёр талт захиалга тасралтгүй байршуулж ажиллах юм. Ингэснээр MFC хувьцааны хөрвөх чадвар нэмэгдэж, арилжааны идэвх болон хүртээмж сайжрах боломж бүрдэнэ.

Цаашид бид Монголын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор I ангиллын 4–5 компанийн хувьцаанд зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

МХБ БОЛОН BGM ASSET MANAGEMENT ХАМТРАН 800 ГАРУЙ ШИЛДЭГ КОМПАНИЙГ БАГТААСАН FTI ИНДЕКСИЙГ ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж болон BGM Asset Management хамтран олон улсын зах зээлд чиглэсэн анхны FTI (Future Tech Innovation) индексийг албан ёсоор тооцож эхэллээ. Энэхүү индекс нь АНУ-ын технологийн салбар болон түүнтэй стратегийн уялдаа бүхий түүхий эд, эрчим хүчний компаниудын гүйцэтгэлийг нэгтгэн харуулдаг бөгөөд дэлхийн 800 гаруй компанийн хувьцааг хамарсан өргөн хүрээтэй үзүүлэлт юм.




FTI индекс нь хөрөнгө оруулагчдад нэг компанид төвлөрөхгүйгээр олон салбар, олон компанийн зах зээлийн чиг хандлагыг нэг дороос харах боломж олгож байна. Индексийн багцын шинэчлэлтийг жил бүр, дахин тэнцвэржүүлэлтийг хагас жил тутам хийхээр төлөвлөжээ.

Энэхүү индексийг нэвтрүүлснээр Монголын зах зээлд түүнд суурилсан шинэ хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүд хөгжих боломж бүрдэж, дотоодын хөрөнгө оруулагчдад дэлхийн технологийн өсөлтөд оролцох шинэ гарц нээгдэж байна.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

Ногдол ашигт суурилсан хөрөнгө оруулалт хийхэд мэдэж байх ёстой өдрүүд

Компаниудын хувьцааг эзэмшиж ногдол ашиг авахын тулд доорх өдрүүдийг зайлшгүй мэдэж байх ёстой. Монгол улсын хувьд Т+2 төлбөр тооцооны системийн дагуу гүйлгээ хийгддэг учраас бүртгэлийн өдрөөс 2 хоногийн өмнө тухайн хувьцааг худалдаж аван ногдол ашиг авах боломжтой болдог.

Зарлах өдөр /Declare date/	Хувьцаа авсан байх өдөр /Ex-Dividend date/	Бүртгэлийн өдөр /Record date/	Төлбөрийн өдөр /Payable date/
2026.02.19 өдөр ТУЗ-ийн тогтоолоор зарласан.	2026.03.20 өдөрт амжиж ХЭ болсон байх ёстой.	2026.03.22 өдөр ногдол ашиг авах эрхтэй ХЭ-н жагсаалт гаргана.	2026.04.30 өдөр ҮЦТХТ дансаар олгоно.

Энэ нь ямар нэг компанийн бодит жишээ биш бөгөөд зохиомол өдрүүд болно.